

**“ОЛОН УЛС СУДЛАЛ 2021-МОНГОЛЫН ОРОС СУДЛАЛ”  
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРЛЫГ НЭЭЖ,  
ШУА-ИЙН ДЭД ЕРӨНХИЙЛӨГЧ, АКАДЕМИЧ  
Г.ЧУЛУУНБААТАРЫН ХЭЛСЭН ҮГ**

Эрхэм хүндэт эрдэмтэн судлаачид Та бүхний энэ өдрийн түмэн амрыг эрж мэндчилье.

Энэ онд Монгол Улс, ОХУ-ын хооронд дипломат харилцаа тогтоосны 100 жил, Монгол Улсад орчин цагийн шинжлэх ухааны байгууллага үүсэж хөгжсөний 100 жил, ШУА байгуулагдсаны 60 жилийн түүхт ой тус тус тохиож, ОХУ, Монгол Улсын эрдэм шинжилгээний байгууллагууд, эрдэмтэн судлаачид энэхүү түүхт ойнуудаа эрдэм судлалын амжилт ололтоор дүүрэн угтаж, бас олон чухал хөтөлбөр, арга хэмжээг хамтран хэрэгжүүлсээр байгаа билээ.

Хоёр улсын хооронд дипломат харилцаа тогтоон хөгжсөн энэхүү зуун жилийн түүхэн замнал бол Монгол Улсын эдийн засаг, нийгэм, соёл, оюун санааны амьдралын бүхий л хүрээг хамарсан Монгол-Оросын ард түмний хамтын хөгжил дэвшлийн бахархам сайхан түүх билээ. Зуунаар өртөөлсөн энэ хөлгөн их түүхэнд Орос, Монголын шинжлэх ухааны салбарын найрамдал хамтын ажиллагаа чухал байр суурийг эзэлдэг бөгөөд ялангуяа, мөнхийн их хөрш ах дүүгийн найрамдалт Орос улсын орон судлалын судалгаанд онцгой анхаарсаар ирсэн байдаг.

Манай улсын шинжлэх ухааны хөгжил Оросын шинжлэх ухаан, эрдэмтэдтэй салшгүй холбоотойгоор хөгжиж ирсэн болохыг хоёр улсын эрдэмтдийн хамтдаа бүтээсэн томоохон нээлт, бүтээлүүд гэрчлэн харуулахын зэрэгцээ бүтэн зууны туршид найрамдан хөршилж ирсэн аугаа их Орос орон, Оросын ард түмнийг илүү сайн судлан мэдэх нь түүхийн аль ч үед манай түүх, орон судлалын судалгааны нэгэн тэргүүлэх чиглэл болсоор байгаа юм .

Орос, Монгол хоёр улсын хооронд дипломат харилцаа тогтоосны зуун жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд Монгол Улсын Шинжлэх Ухааны Академиас ОХУ-ын ШУА-ийн Дорно дахины хүрээлэн, Эрхүүгийн их сургууль, Буриадын Эрдэм шинжилгээний хүрээлэн зэрэг байгууллагуудтай хамтран олон улсын эрдэм шинжилгээний хурал, архивын баримт, түүхэн гэрэл зургийн үзэсгэлэн зохион байгууллаа.

ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгээс сүүлийн жилүүдэд “Олон улс судлал” уламжлалт цуврал хурлаа сэргээн зохион байгуулж эхлээд байгаа бөгөөд өнөөдөр та бүхний оролцож буй “Олон улс судлал 2021-Монголын Орос судлал” эрдэм шинжилгээний хурал нь Монгол Улс, ОХУ-ын харилцааны түүхт ойд

зориулсан цуврал арга хэмжээг отголж буйгаараа онцлог болж байна.

Тус эрдэм шинжилгээний хурлаар Монгол, Оросын харилцааны түүх, улс төр, эдийн засаг, худалдаа, шинжлэх ухаан, батлан хамгаалах, архивын салбарын хамтын ажиллагаа зэрэг өргөн асуудлаар ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэн, Түүх, угсаатны зүйн хүрээлэн, Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэн, Архивын Ерөнхий газар, Стратеги судлалын хүрээлэн, Үндэсний тагнуулын академийн 12 эрдэмтэн, судлаачид илтгэл хэлэлцүүлэх юм байна. Мөн уг хуралд манай ШУА, их, дээд сургуулийн орос судлаач эрдэмтэн профессорууд оролцож, санал бодлоо уралдуулахаар хүрэлцэн ирсэнд баяртай байгаагаа илэрхийлье.

Цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан ОХУ-аас эрдэмтэд биечлэн хүрэлцэн ирж оролцох боломжгүй байгаа ч цахимаар оролцож, бидний зохион байгуулж буй эрдэм шинжилгээний хурлыг дэмжсэн орос анд нөхдөдөө их баярлалаа.

“Олон улс судлал 2021-Монголын Орос судлал” эрдэм шинжилгээний хурал нь “Монголын Орос судлал”, “Монгол-Оросын харилцаа, хамтын ажиллагаа” гэсэн 2 үндсэн хэсэгт хандан ОХУ-ын гадаад бодлого, аюулгүй байдлын стратегиас эхлээд Монголын Орос судлалд тулгамдаж буй асуудлуудыг дүгнэн хэлэлцэхийн зэрэгцээгээр хоёр орны өргөн хүрээтэй харилцаа, хамтын ажиллагааны түүх, орчин үеийн төлөв байдалд чиглэсэн олон сонирхолтой илтгэл хэлэлцүүлж, ажил хэрэгч санал, зөвлөмж гарсан өгөөжтэй хурал болно гэдэгт итгэлтэй байна.

Ингээд Та бүхэнд Монгол Улс, ОХУ-ын хооронд дипломат харилцаа тогтоосны түүхт 100 жилийн ойн мэндийг өргөн дэвшүүлж, “Олон улс судлал 2021-Монголын Орос судлал” эрдэм шинжилгээний хурлыг нээснийг мэдэгдэж байна.

Эрдэм шинжилгээний хурлын үйл ажиллагаанд амжилт хүсье.

*Улаанбаатар хот  
2021 оны 12 дугаар сарын 20-ны өдөр*